

## 2 Аудитын тайлан

### 2.1 Оршил

Соёл урлагийн их сургуулийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайланг Соёл урлагийн их сургуулийн захирал Э. Сонинтогос танд танилцуулж байна.

Энэхүү тайланд Соёл урлагийн их сургуулийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд улсын бүртгэлийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулах, сургууль хоорондын тооцоог бүрэн хийдэг байх, хувь иргэнд олгосон ажил үйлчилгээний төлбөрөөс ХХОАТ-ыг суутган тооцож тайлагнадаг байх, анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэхгүй байх, үндсэн хөрөнгө худалдан авахдаа холбогдох хууль тогтоомжийн дагуу зөвшөөрөл авдаг байх талаар зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

### 2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Соёл урлагийн их сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн санхүүгийн тайланд /САГ-2018/115/СТА-ТӨҮГ / аудит хийлээ.

Аудитыг тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Соёл урлагийн их сургуулийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон

01

ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Соёл урлагийн их сургуулийн удирдлага санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан Сангийн сайдын холбогдох журмууд, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайланг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 1 дүгээр сарын 25-наас 2018 оны 3 дугаар сарын 9-ний хооронд хийж 2018 оны 3 дугаар сарын 15-нд эцэслэн баталгаажуулж, Соёл урлагийн их сургуулийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн Энич Аудит ХХК-ийн ахлах аудитор Б.Итгэлтээр ахлуулсан баг хэрэгжүүлэв.


Соёл урлагийн их сургуулийн 2017 оны санхүүгийн тайланг Энич Аудит ХХК-д 2018 оны 3 дугаар сарын 07-ны өдөр 01/148 тоот албан бичгээр хуулиар тогтоосон хугацааг 21 хоногоор хожимдуулж ирүүлсэн.

### **2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Соёл урлагийн их сургууль нь санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Боловсролын тухай, Дээд боловсролын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон Нийгмийн даатгалын тухай, Татварын багц хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Соёл урлагийн их сургууль нь Хөгжмийн урлагийн сургууль, Театрын урлагийн сургууль, Дүрслэх, дизайны урлагийн сургууль, Радио, телевиз медиа урлагийн сургууль, Соёлын сургууль, Бүжгийн урлагийн сургууль гэсэн бүтцийн 6 сургууль, салбар сургууль болох Завхан аймаг дахь Хөгжим бүжгийн коллеж, Гадаад хэлний институт, Соёл урлаг судлалын хүрээлэн, Бадмаараг ахлах сургууль, 4 төв, 25 тэнхим, 10 профессорын баг, захиргааны 5 газар, нэгжтэйгээр сургалт, эрдэм шинжилгээ, уран бүтээлийн үйл ажиллагаа явуулж байна.

Тус сургууль нь 480 профессор багш ( үндсэн 282, гэрээт болон цагийн багш 198 ), 197 ажилтан, ажилчид, 175 докторант, 395 магистрант, бакалаврын 3177



дипломын 4 оюутан, Завханы ХБК, Бадмаараг ахлах сургуулийн 424 сурагч, нийт 4175 суралцагчтай.

Соёл урлагийн их сургуулийн эрхэм зорилго нь байгууллагын дүрэмд зааснаар Монголчуудын уламжлалт соёл урлагийн үнэт зүйлийг орчин үеийн дэвшилтэт ололттой хослуулан эзэмшсэн, дэлхийн урлагт хуримтлуулсан мэдлэгээс суралцсан дэлхийн соёл, урлагт хувь нэмрээ оруулан, Монголын соёлыг хүн төрөлхтний өвийн салшгүй хэсэг болгож чадах мэргэжилтэн, судлаач, уран бүтээлч бэлтгэнэ. Нийгмийн эрэлтэд тулгуурлан сургалтын стандартад нийцүүлэн диплом, бакалавр, магистр, докторын зэрэг олгох, богино хугацааны мэргэжил дээшлүүлэх, хос хавсарсан хөтөлбөрөөр сургалт эрхэлж, мэргэжлийн болон иргэний өндөр боловсрол, чадвартай мэргэжилтэн бэлтгэх, шинэ мэдлэг бүтээж, сургалт судалгааны эргэлтэнд оруулах, нийтэд түгээх, нийтийн соёл, мэргэжлийн урлагийн түвшнийг дээшлүүлэхэд үндсэн чиг үүрэг оршино” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрхи зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “ байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18-д “ бусад байгууллагын дарга (захирал, эрхлэгч) тухайн байгууллагын ” гэж заасны дагуу Соёл урлагийн их сургуулийн захирал Э.Сонинтогос нь захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Төсвийн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, байгууллагатай холбоотой зарим хууль, журам, зааврыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Соёл урлагийн их сургуулийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээгээр судалж баримтжуулсан.

#### **2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, АОУС, тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиудыг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Соёл урлагийн их сургуулийн 2017 оны санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх зорилгоор удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

тулд санхүүгийн тайлангийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Горим сорилыг гүйцэтгэхэд илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг 2.9-д хураангуйлан тэмдэглэв. Соёл урлагийн их сургуулийн үйл ажиллагаанд 2017 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/400 тоот тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцсэн байна.

Соёл урлагийн их сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Соёл урлагийн их сургуулийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програмаар боловсруулан санхүүгийн тайланг бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.


## 2.5 Дотоод аудит

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Соёл урлагийн их сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад орон тооны дотоод аудитор ажилладаг боловч дотоод хяналт сул байна.

## 2.6 Орлого, зардлын талаарх тайлбар, тодруулга

2017 онд нийт орлого нь 10,337.4 сая төгрөг, нийт зардал нь 10,110.9 сая төгрөг, үйл ажиллагааны нийт үр дүн нь 190.8 сая төгрөг байна.

Соёл урлагийн их сургуулийн удирдлага нь 2017 онд зардлыг санхүүжүүлэх орлогын эх үүсвэр 11,836.7 сая төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 10,589.6 сая төгрөг гарч 89.5 хувийн биелэлттэй байгаа нь орлогын төлөвлөгөөнд урьд оны дансны үлдэгдлээс зарцуулах 1,682.4 сая төгрөг батлагдсантай холбоотой байна.



Мөн урсгал зардалд 11,836.7 сая төгрөг батлагдсанаас 9,895.1 сая төгрөгийг зарцуулсан байна. Батлагдсан төсвөөс цалин хөлсний зардлыг 671.7 сая төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 61.9 сая төгрөгөөр, ашиглалтын зардлыг 93,6 сая төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 94,9 сая төгрөгөөр, эд хогшил урсгал засварын зардлыг 224.7 сая төгрөгөөр, томилолтын зардлыг 68.9 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 22.1 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 402.3 сая төгрөгөөр, бусад урсгал шилжүүлгийг 7.1 сая төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 294.4 сая төгрөгөөр нийт 1,941.6 сая төгрөгөөр буюу 16.4 хувийн хэмнэлттэй зарцуулсан байна.

## 2.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу захирагчийн шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хангах зорилтын хүрээнд <http://shilendans.gov.mn/org/1133> сайтад Соёл урлагийн их сургуулийн 2017 оны батлагдсан төсөв, болон орон тоонд орсон өөрчлөлтийн мэдээллийг хуулийн хугацаанд байршуулан ажиллаж байна. Тайлант онд Соёл урлагийн их сургуулийн хувьд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 218 гүйлгээгээр 2,534.6 сая төгрөг, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 78 гүйлгээгээр 804.3 сая төгрөгийн мэдээллийг байршуулсан байна.

## 2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 23 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд нийт 15 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Соёл урлагийн их сургуулийн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, орлого, цалин хөлс, зардал зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 40 хувь, мөнгөн хөрөнгийн 60 хувь, нийт зардлын 60 хувь, нийт хөрөнгийн 60 хувийг тус тус эзэлж байна. Горим сорилыг гүйцэтгэхэд илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

## 2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 37,6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүллээ.

01

ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

### 2.9.1 Үндсэн хөрөнгийн талаар

Тайлант хугацаанд холбогдох хууль, тогтоомжийн дагуу зөвшөөрөл аваагүй 512,5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 4-т "Төрийн өмчит ... үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасаж шилжүүлэх, устгах саналаа төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 3.2-т "Төрийн өмчит хуулийн этгээд нь өөрийн чиг үүрэг зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай эд хөрөнгийн жагсаалтыг гарган хуульд заасан хугацаанд төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраар батлуулна" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хууль болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ыг мөрдөж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх.

### 2.9.2 Эзэмшигчийн өмчийн талаар

Улсын бүртгэлийн гэрчилгээн дэх өөрийн хөрөнгийн дүн санхүүгийн тайлангаарх дүнгээс 711.6 сая төгрөгөөр дутуу тусгагдсан байна.

Энэ нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4-т заасан "Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх өргөдлийг энэ хуулийн 13.3, 15.1, 16.1-д заасны дагуу гаргана", 11 дүгээр зүйлийн 11.3-т заасан "Энэ хуулийн 11.1-д заасан мэдээлэлд өөрчлөлт оруулсан бол тухайн хуулийн этгээд ажлын 15 өдрийн дотор энэ талаар улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэнэ" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох хуульд заасны дагуу улсын бүртгэлийн гэрчилгээндээ өөрийн хөрөнгийн дүнгийн өөрчлөлтийг тусгах талаар зөвлөмж хүргүүлэх.

### 2.9.3 Сургалтын авлага, өглөгийн талаар

Сургууль хоорондын сургалтын төлбөрийн тооцоог нийлээгүйн байдлаас авлага, өглөгийн үлдэгдэл нь 1.5 сая төгрөгөөр илүү илэрхийлэгдсэн байна.

01

ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

Энэ нь УСНББОУС 1-ийн 27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас өмнө хянан, баталгаажуулах " гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: УСНББОУС 1 болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтыг мөрдлөг болгон ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх.

#### 2.9.4 Бараа материалын талаар

Бараа материалын түүвэрчилсэн тооллого хийхэд ашиглалтын шаардлага хангахгүй дараах бараа материалууд бүртгэлтэй байна. Үүнд: барааны сав баглаа боодлыг 3.7 сая төгрөгөөр бараа материал дансанд орлого авсан, 0.5 сая төгрөгийн өртөгтэй 6 ш эвдэрч гэмтсэн индүү бараа материалын үлдэгдэлд байна.

Сэтгүүлийн урьдчилгаа төлбөрт 0.6 сая төгрөг шилжүүлж бараа материал дансанд бүртгэсэн.

Энэ нь УСНББОУС 1-ийн 27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой", УСНББОУС 12-ийн 9-ийн Б-д "Үйлчилгээ үзүүлэхэд хуваарилагдах эсвэл хэрэглэгдэх материал буюу хангамжийн зүйл хэлбэрээр байгаа" гэсэн заалт болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж санхүүгийн тайлан гаргах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: УСНББОУС 1.27, 2.9 болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтыг мөрдлөг болгон ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх.

#### 2.9.5 Зардлын талаар

2017 онд нийт бараа үйлчилгээний бусад зардлаас 27.0 сая төгрөгийн зөрчил илэрснээс 7.0 сая төгрөгийн зардал нь анхан шатны баримтын иж бүрдэл дутуу, 0.6 сая төгрөгийн зардал нь анхан шатны баримтгүй байна. Мөн 2018 оны хэвлэлийн захиалгын урьдчилгаа төлбөр болох 6.8 сая төгрөгийг урьдчилж төлсөн тооцоо дансанд бүртгээгүй, баримтат кино бүтээлгэсэн 12.5 сая төгрөгийн өртгийг үндсэн хөрөнгө дансанд бүртгэлгүй тайлант хугацааны зардалд тус тус бүртгэсэн байна.

Энэ нь УСНББОУС 1-ийн 27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой", УСНББОУС 17 болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж санхүүгийн тайлан гаргах" , 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх " гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: УСНББОУС 1, 17 болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4, 20.2.3 дахь заалт, 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалтыг мөрдөж ажиллах талаар 26.4 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлэх, 0.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоох.

#### 2.9.6 Орлого, зардлын талаар

Төгсөгчдийн бүтээлийн каталоогоос 125 ширхэгийг 2.9 сая төгрөгөөр борлуулж, орлого болон төлбөрийн шилжүүлгийн гүйлгээг данс бүртгэлд тусгаагүй орхигдуулсан байна.


Энэ нь УСНББОУС 1-ийн 27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой" болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийн заавал бүртгэнэ", 14.4.1-д "Аж ахуйн бүх ажил гүйлгээ" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: УСНББОУС болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 14.4.1 дэх заалтуудыг мөрдөж ажиллах, цаашид ажил гүйлгээг орхигдуулан бүртгэхгүй байх талаар зөвлөмж хүргүүлэх.

#### 2.9.7 Томилолтын зардлын талаар

Томилолтын зардлын тооцоог үүсгэх дансны давхар бичилт хийхдээ мөнгөн хөрөнгө дансны кредит, өглөг дансны дебет гэж бүртгэдэг байна. Мөн гадаад, дотоодын томилолтын зөрүү болох зочид буудлын төлбөрийн үлдэгдэл 0,9 сая төгрөгийг холбогдох ажилтнуудаас авлагын тооцоо үүсгэлгүй тайлант хугацааны зардалд бүртгэсэн байна.

Энэ нь УСНББОУС 1 болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д " Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас өмнө хянан, баталгаажуулах " , 13 дугаар зүйлийн 13.7-д заасан "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг тус тус зөрчсөн байна





Шийдвэрлэсэн нь: УСНББОУС 1 болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалтуудыг мөрдөж ажиллах талаар зөвлөмж хүргүүлж, 0.9 сая төгрөгт төлбөрийн акт тогтоох.

#### 2.9.8 ХХОАТатварын талаар

Хувь хүмүүст олгосон бараа үйлчилгээний дүнгээс 0.3 сая төгрөгийн ХХОАТ-ыг суутган тооцож, тайлагнаагүй байна.

Энэ нь ХХОАТ-ын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.7-д заасан “Энэ хуулийн 15.1.1-15.1.6-д заасантай адилтгах бусад орлого” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: ХХОАТ-ын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.7 дахь заалтыг мөрдөж ажиллах, төлбөрийн акт тогтоох.

#### 2.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Соёл урлагийн их сургуулийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад анхаарал татахуйц чухал асуудал байхгүй.

#### 2.11 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Соёл урлагийн их сургуулийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

#### 2.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Соёл урлагийн их сургуулийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 37.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 1.9 сая төгрөгийн зөрчилд 1 акт, 35.7 сая төгрөгийн алдаа, зөрчилд 7 зөвлөмж өгөгдсөн.

#### 2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Соёл урлагийн их сургуулийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг “Баян Ташаагийн Эх Аудит” ХХК гүйцэтгэсэн ба аудитаар 290.1 сая төгрөгийн алдаа илэрснээс 7 зөвлөмж өгөгдөж, зөвлөмжүүд бүгд хэрэгжсэн байна.

#### 2.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Төлөвлөлтийн явцад нийт зардлын хүлээгдэж буй гүйцэтгэлийн дүнгээс 1% буюу 104.6 сая төгрөгөөр материаллаг байдлыг тогтоосон. Гүйцэтгэлийн шатанд дахин тооцох шаардлагагүй гэж үзлээ.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Соёл урлагийн их сургуулийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Соёл урлагийн их сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан 9 хуудас, хавсралтууд болон санхүүгийн бусад холбогдох материал 160 хуудас тус тус хавсаргав.

### 3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

---

“Энич Аудит” ХХК аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Соёл урлагийн их сургуулийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгав.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Соёл урлагийн их сургуулийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс менежментийн захидалд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.

3. УДИТЫН ЯВЦАД ӨГСӨН ЗӨВЛӨМЖ, ЗАХИРАГЧИЙН ХАРИУ

3.1 Үндсэн хөрөнгийн талаар	Тэргүүлэх ач холбогдол №1
-----------------------------	---------------------------

ҮАГ-ын ажиглалт

Тайлант хугацаанд холбогдох хууль, тогтоомжийн дагуу зөвшөөрөл аваагүй 512,5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 4-т "Төрийн өмчит ... үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасаж шилжүүлэх, устгах саналаа төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 86-р тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 3.2-т "Төрийн өмчит хуулийн этгээд нь өөрийн чиг үүрэг зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай эд хөрөнгийн жагсаалтыг гарган хуульд заасан хугацаанд төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраар батлуулна" гэж заасныг тус тус зөрчсөн байна. Санхүүгийн тайлангийн үнэн зөв байх батламж мэдэгдэлийг хангаагүй байна.

Эрсдэлүүд

Хууль тогтоомж хэрэгжихгүй байх, үр ашиггүй хөрөнгө бэлтгэх.


ҮАГ-ын зөвлөмж

Үндсэн хөрөнгө худалдан авахдаа "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хууль болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ыг мөрдөж ажиллах

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 06 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.



3.2 Эзэмшигчийн өмчийн талаар	Тэргүүлэх ач холбогдол №2
<p>ҮАГ-ын ажиглалт</p> <p>Улсын бүртгэлийн гэрчилгээн дэх өөрийн хөрөнгийн дүн нь санхүүгийн тайлангаарх дүнгээс 711,6 сая төгрөгөөр дутуу байна. Энэ нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4-т заасан "Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх өргөдлийг энэ хуулийн 13.3, 15.1, 16.1-д заасны дагуу гаргана", 11 дүгээр зүйлийн 11.3-т заасан "Энэ хуулийн 11.1-д заасан мэдээлэлд өөрчлөлт оруулсан бол тухайн хуулийн этгээд ажлын 15 өдрийн дотор энэ талаар улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэнэ" гэж заасныг тус тус зөрчсөн байна. Санхүүгийн тайлангийн үнэн зөв байх батламж мэдэгдэлийг хангаагүй байна.</p>	<p>ҮАГ-ын зөвлөмж</p> <p>Холбогдох хуульд заасны дагуу улсын бүртгэлийн гэрчилгээндээ өөрийн хөрөнгийн дүнгийн өөрчлөлтийг тусгах</p> <p>. Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 06 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх</p>
<p>Эрсдэлүүд</p> <p>Хууль тогтоомж хэрэгжихгүй байх, хэрэглэгчдийг буруу мэдээлэл хангах.</p>	<p>захирагчийн хариу</p> <p>Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.</p>

3.3 Сургалтын авлага, өглөгийн талаар	Тэргүүлэх ач холбогдол №2
---------------------------------------	---------------------------

ҮАГ-ын ажиглалт

Сургууль хоорондын сургалтын төлбөрийн тооцоог нийлээгүйн байдлаас авлага, өглөгийн үлдэгдэл нь 1,5 сая төгрөгөөр илүү илэрхийлэгдсэн байна. Энэ нь УСНББОУС 1-ийн 27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас өмнө хянан, баталгаажуулах " гэж заасныг тус тус зөрчсөн байна. Санхүүгийн тайлангийн оршин байх, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайланд авлага, өглөгийн үлдэгдэл буруу илэрхийлэгдэх.

ҮАГ-ын зөвлөмж

УСНББОУС 1 болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтыг мөрдлөг болгон ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 06 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

3.4 Бараа материалын талаар	Тэргүүлэх ач холбогдол №2
-----------------------------	---------------------------

ҮАГ-ын ажиглалт

Бараа материалын түүвэрчилсэн тооллого хийхэд ашиглалтын шаардлага хангахгүй дараах бараа материалууд бүртгэлтэй байна. Үүнд: барааны сав баглаа боодлыг 3.7 сая төгрөгөөр бараа материал дансанд орлого авсан, 0.5 сая төгрөгийн өртөгтэй 6 ш эвдэрч гэмтсэн индүү бараа материалын үлдэгдэлд байна.

Сэтгүүлийн урьдчилгаа төлбөрт 0.6 сая төгрөг шилжүүлж бараа материал дансанд бүртгэсэн.

Энэ нь УСНББОУС 1-ийн 27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой", УСНББОУС 12-ийн 9-ийн Б-д "Үйлчилгээ үзүүлэхэд хуваарилагдах эсвэл хэрэглэгдэх материал буюу хангамжийн зүйл хэлбэрээр байгаа" гэсэн заалт болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж санхүүгийн тайлан гаргах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Санхүүгийн тайлангийн оршин байх, үнэн зөв байх батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

Эрсдэлүүд

Бараа материалын өртөг болон нөөц буруу тооцогдох, санхүүгийн тайланд зөрүүтэй илэрхийлэх.


ҮАГ-ын зөвлөмж

УСНББОУС 1.27, 2.9 болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтыг мөрдлөг болгон ажиллаж талаар зөвлөмж хүргүүлэх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 06 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.



3.5 Зардлын талаар	Тэргүүлэх ач холбогдол №2
--------------------	---------------------------

ҮАГ-ын ажиглалт

2017 онд нийт бараа үйлчилгээний бусад зардлаас 27.0 сая төгрөгийн зөрчил илэрснээс 7.0 сая төгрөгийн зардал нь анхан шатны баримтын иж бүрдэл дутуу, 0.6 сая төгрөгийн зардал нь анхан шатны баримтгүй байна. Мөн 2018 оны хэвлэлийн захиалгын урьдчилгаа төлбөр болох 6.8 сая төгрөгийг урьдчилж төлсөн тооцоо дансанд бүртгээгүй, баримтат кино бүтээлгэсэн 12.5 сая төгрөгийн өртгийг үндсэн хөрөнгө дансанд бүртгэлгүй тайлант хугацааны зардалд тус тус бүртгэсэн байна.

Энэ нь УСНББОУС 1-ийн 27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой", УСНББОУС 17 болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж санхүүгийн тайлан гаргах" , 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх " гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлангийн хөрөнгийн дүн болон тайлант хугацааны үр дүн буруу илэрхийлэгдэх.

ҮАГ-ын зөвлөмж

УСНББОУС 1, 17 болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4, 20.2.3 дахь заалт, 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалтыг мөрдөж ажиллах.

